



ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 оны 6-р сарын 30-ны байдлаар



"Хүүхэд бүр уран бүтээлч" уралдааны
8-10 насны ангиллын тэргүүн байр
Г.Нандингийн бүтээл.



“Хүүхэд бүр уран бүтээлч” уралдааны
14-16 насны ангиллын тэргүүн байр
Минсо Гилийн бүтээл.


Агуулга

1. Онцлох үйл явдал	02-07
2. Санхүүгийн үзүүлэлтүүд	08-13
3. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	14-15
4. Компанийн засаглал	16

Онцлох үйл явдал



2026 оны II улирал



Төлбөрөө Google Pay-дээ!

Орчин үеийн төлбөр тооцооны шилдэг шийдлүүдийн нэг Google Pay үйлчилгээг ХасБанк нэвтрүүлээ. Тус үйлчилгээнд ХасБанкны бүх төрлийн Visa дебит картаа холбосноор үйлдлийн системтэй гар утсаараа өдөр тутмын худалдан авалтынхаа төлбөр тооцоог хурдан, аюулгүй хийх боломжтой.

 | 



ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ 3

ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай

₮172.6 тэрбум
2025 Цэвэр Ашиг

₮50.4 тэрбум
2025 оны нийт ногдол ашиг


Төрөл	Үнэ (тэрбум)
2025 эхний хагас ногдол ашиг	₮18.9
2025 сүүлийн хагас ногдол ашиг	₮31.5
Хөрөнгө Оруулалт 2026 (CAPEX)	₮2.1
2025 Хувьцаа халааслах	₮21.7

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал боллоо

ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулагдаж, ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах, хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Онцлох үйл явдал

2026 оны II улирал



Онцлох үйл явдал



2026 оны II улирал



Шилдэг татвар төлөгч

ХасБанк 2025 онд нийт 112 тэрбум төгрөгийн татвар, хураамж, шимтгэлийг улсын төсөвт төвлөрүүлсэн амжилтаар "Том татвар төлөгчийн сегмент"-ийн ТОП-5 байгууллагын нэгээр шалгарлаа.




ЕСБХБ-аас 80 сая ам.долларын санхүүжилт авлаа

ХасБанк бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч, 35 хүртэлх насны залууст чиглэсэн 80 сая ам.долларын санхүүжилтийн гэрээг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай зурлаа. Тус санхүүжилт нь талуудын хооронд 2025 оны 3-р сард байгуулагдсан 147 сая ам.долларын синдикат зээлийн хэлцлийн үргэлжлэл юм.

Онцлох үйл явдал

2026 оны II улирал



Онцлох үйл явдал




2026 оны II улирал



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

- Харилцагч зээлийн эргэн төлөлтийн хуваариа өөрийн онцлогт тохируулан зохиох боломж бүрдлээ.
- Дижитал банкаараа зээлийн эргэн төлөлтөө хойшлуулах боломжтой боллоо.
- Автомашины торгуулиа дижитал банкаар төлдөг боллоо.
- Гадаадад оршин суугаа иргэддээ эх орондоо орон сууц худалдан авахад зориулсан хадгаламжийн бүтээгдэхүүн нэвтрүүллээ.
- Засгийн газартай хамтарсан хүүгийн татаастай, хөнгөлөлттэй зээлүүд болох Тариалан үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих зээл, Ноолуур боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих зээл, Аялал жуулчлалыг дэмжих зээлийн хөтөлбөрүүд хэрэгжиж байна.
- 7-17 насны хүүхдүүдэд зориулсан ХасTeen+ application-ын шинэчилсэн хувилбарыг нэвтрүүлж, харилцагч хүүхдүүдийн бүртгэл хийх үйл явцыг хялбаршууллаа.



Онцлох үйл явдал



2026 оны II улирал



Нийгмийн хариуцлага

- Олон улсын Туялзуур сэлэмний холбооны IUFC LEAGUE ULAANBAATAR 2026 тэмцээнийг ивээн тэтгэж, дэмжин ажиллалаа. Азийн бүсийн шилдэг клубүүдийн 180 гаруй залуу тамирчин Улаанбаатрын тэнгэр дор цуглан ур чадвар, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм.
- Монголын Паралимпын шатрын холбооны анхдугаар улсын аварга шалгаруулах тэмцээнийг ивээн тэтгэн, оюуны спортыг дэмжлээ. Тэмцээнд нийслэл болон орон нутгийн нийт 78 шатарчин цуглаж, Харааны бэрхшээлтэй B1, B2-B3, Сонсголын бэрхшээлтэй, Тулгуур эрхтний бэрхшээлтэй гэсэн 4 төрөлд эрэгтэй, эмэгтэй ангиллаар өрсөлдөн аваргаа тодруулсан юм.
- Хасын хүлэгүүд баг Монголын үндэсний дээд лигийн аваргын алтан цомыг 10 дахь удаагаа өргөж, түүх бүтээлээ.
- ХасTeen+ апп-ын нэрэмжит сагсан бөмбөг, волейболын тэмцээнийг Дорнод, Өвөрхангай, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл аймгуудад амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 237 багийн нийт 2,200 гаруй хүүхэд багачууд, өсврийн тамирчид багш дасгалжуулагчдын хамт оролцон өрсөлдөж, шилжин явах цомын эздийг тодруулав.
- Erxes academy-тай хамтран жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдадаа зориулан "SME AI Masterclass" сургалтыг зохион байгуулж, үйл ажиллагаагаа илүү хурдтай, илүү бүтээмжтэй, илүү оновчтой болгон бизнесээ шинэ шатанд гаргах эхлэлийг тавьлаа.

Санхүүгийн үр дүн



2026 оны II улирал

Цэвэр ашиг	ROE	ХАС (Хувьцааны ханш)	EPS	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
₮45.8 тэрбум	20.0%	₮1,265	₮168.1	18.4%	33.3%

Ашигт ажиллагаа

- 2026 оны II улиралд ХасБанкны татварын дараах ашиг 45.8 тэрбум төгрөгт хүрч өссөн дүнгээр цэвэр ашиг 88.2 тэрбум төгрөг буюу өмнөх жилийн мөн үеэс 2.7% өссөнөөр нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) 168.1 төгрөгт хүрлээ.
- Тайлант хугацаанд үйл ажиллагааны нийт орлого 100.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх улирлаас 10.0 хувиар өссөн ба үүнд зээлийн багцын тэлэлтээс шалтгаалсан хүүгийн цэвэр орлогын өсөлт голчлон нөлөө үзүүлжээ.
- 2025 онд зардал-орлогын харьцаа үзүүлэлт 37.3 хувь байсан бол зардлын удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлснээр 36.1 хувь болон сайжирсан байна.
- Өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 20.0 хувьд хүрч өмнөх улирлаас 0.6 суурь нэгжээр өссөн байна.

Баланс

- Нийт хөрөнгө өмнөх улирлаас 10.2 хувиар өсөж 7,508 тэрбум төгрөгт хүрснээр I улирлын 0.7 хувийн бууралтыг эргэн нөхөв. Хүүгийн орлого олдог актив өмнөх улирлаас 13.1 хувиар өсөж, 6,574 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт хөрөнгийн 88 хувийг бүрдүүлж байна.
- Зээлийн өсөлт мэдэгдэхүйц эрчимжиж, нийт зээлийн багц өмнөх улирлаас 11.8 хувиар өсөж, 4,889 тэрбум төгрөгт хүрсэн нь I улирлын 4.6 хувийн өсөлтөөс ойролцоогоор 2.5 дахин өндөр үзүүлэлт юм. Зээлийн өсөлт сегментүүдийн түвшинд өргөжиж I улиралд буурсан байгууллагын банкны зээлийн багц 940 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 16.9 хувиар өссөн бол Хаслизингийн санхүүгийн түрээсийн багц 18.2 хувиар өсөж 854 тэрбум төгрөг, бизнесийн банкны зээлийн багц 28.1 хувиар өсөж, 324 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Харин иргэдийн зээлийн сегментийн хувьд жижиг дунд бизнесийн зээлийн багц 15.1 хувиар, ипотекийн зээлийн багц 13.0 хувиар тус тус өссөн бол цалингийн зээлийн багц үргэлжлэн буурсаар байна.
- Зээлийн багц эрчимтэй өссөн хэдий ч активын чанар сайжирсаар байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 2.4 тэрбум төгрөгөөр буурч 105.9 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн харьцаа 2.2 хувьд хүрсэн нь өмнөх улирлаас 0.3 хувиар буурсан үзүүлэлт юм.
- Нийт харилцах, хадгаламж хурдацтай өсөж 4,025 тэрбум төгрөгт хүрч, өмнөх улирлаас 9.2 хувиар өссөн байна. Харилцах дансны үлдэгдэл улирлын шинжтэй бууралтын дараа өмнөх улирлаас 28.6 хувиар өссөн нь багцын өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн бол хугацаатай хадгаламж 4.5 хувиар, ирээдүйн саятан хадгаламж 1.7 хувиар тус тус өссөн байна.
- 2026 оны II улиралд гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 623 сая ам.долларт хүрч 2025 оны эцсийн 548 сая ам.доллар болон 2026 оны I улирлын 530 ам.доллараас өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлт нь II улиралд татан төвлөрүүлсэн шинэ эх үүсвэрүүд болон хуваарьт эргэн төлөлтүүдийг төлсний дараах цэвэр өсөлтийг илэрхийлж байгаа бөгөөд тус эх үүсвэрүүдийг зээлийн багцын өсөлтийг санхүүжүүлэхэд зарцуулсан.

Харьцаа үзүүлэлт


- 2026 оны II улирлын байдлаар Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохих хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 18.4 хувь буюу доод хэмжээг 5.9 нэгж хувиар давуулан биелүүлсэн байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2026 оны 6 сарын 30-ны байдлаар 33.3 хувьтай байгаа нь зохистой харьцааг хангаж байна.

Санхүүгийн үзүүлэлтийн тренд

2026 оны II улирал


Цэвэр ашиг

Тэрбум төгрөг




Нийт актив

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж

Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

Байвал зохих доод хэмжээ 12.5%



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

Байвал зохих доод хэмжээ 25.0%



Зээлийн үйл ажиллагаа




2026 оны II улирал

Нийт зээлийн тоо	Онлайн зээлийн тоо	Иргэдийн банк зээлийн тоо	Байгууллагын банк зээлийн тоо	Бизнесийн банк зээлийн тоо	ХасЛизинг с.түрээсийн тоо
208.8 мянга ▼ -3.6% QoQ	135.3 мянга ▼ -5.9% QoQ	202.4 мянга	0.2 мянга	0.4 мянга	5.9 мянга

Зээлийн багц

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



Нийт дансны тоо

1.6сая  +1.6% QoQ

992.7 мянга

563.0 мянга

1.2сая ▲ 1.1% QoQ

Period	Number of Employees	Change (%)
25-I	3,366	-
25-II	3,421	-
25-III	3,546	+5.7%
25-IV	3,749	-1.7%
26-I	3,686	+9.2%
26-II	4,025	-

Төрөөм төгсөг

26-I 26-II

Харилцах	Хадгаламж
26-I	26-I
845	2,841
26-II	26-II
1,081	2,944
+27.9%	+3.6%

- 77


Гадаад эх үүсвэр

2026 оны II улирал

2026 оны II улиралд 2025 оны 12 сард Нидерландын Хөгжлийн Агентлагтай байгуулсан синдикат зээлийн гэрээний хүрээнд 150 сая ам.доллар, шинээр DWM, BlueOrchard байгууллагуудаас 5 сая ам.доллар болон 15 сая ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлээд байна. Улмаар нийт гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 623 сая ам.долларт хүрч, өмнөх улирлаас 93 сая ам.доллараар өсөв. Мөн ХасБанк Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктой 80 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ байгуулсан ба үүний 40 сая ам.долларыг 2026 онд татан төвлөрүүлэх боломжтой бөгөөд энэ нь активын өсөлтийг дэмжих нэмэлт санхүүжилт юм.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



Шинээр гадаад эх үүсвэр олгосон байгууллагууд



80 сая ам.доллар

Эх үүсвэр авах гэрээнд гарын үсэг зурснаас 40 сая ам.долларыг нь 2026 онд багтаан ашиглаж, бичил, ЖБД болон залуу бизнес эрхлэгчдийг дэмжихэд зарцуулна.



15 сая ам.доллар

Бичил, жижиг дунд бизнесийн санхүүжилтийг дэмжих зорилгоор төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлээ.



5 сая ам.доллар

Мөн нэмэлтээр DWM-ээс Бичил, жижиг дунд бизнесийн зээлийн өсөлтийг дэмжих зорилгоор төгрөгийн санхүүжилт авсан.

Хувьцааны мэдээлэл


2026 оны II улирал

ХасБанк ХК (ХАС)-ийн хувьцааны үнэ 2026 оны 6 сарын 30-ны өдөр 1,265 төгрөгөөр хаагдаж, өмнөх оны мөн үеийн хаалтын ханшаас 48.8 хувь, IPO хийсэн үнээс 86.9 хувиар өслөө. ХАС-ийн IPO хийснээс хойших нийт өгөөж (хувьцааны үнийн өсөлт болон ногдол ашгийн өгөөжийн нийлбэр) 2026 оны II улирлын байдлаар 105.6% байна.

ХасБанк ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг Монголбанкны холбогдох зөвшөөрлийн дагуу 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд ХасБанкны нийт халаасны хувьцаа 6 сарын 30-ны өдрийн байдлаар 2,853,223 ширхэгт (нийт эргэлтэд гаргасан хувьцааны 0.27%) хүрсэн байна.

2025 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 30 төгрөг буюу нийт 31.4 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараах шийдвэрийг 2026 оны 4 сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлав.


ХАС хувьцааны ханш, нэгж хувьцаанд ногдох өөрийн хөрөнгө



* - 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгийг жилд хөрвүүлэн тооцов.

Ногдол ашиг хуваарилалт

Тэрбум төгрөг



** - IPO ханш буюу нэгж хувьцааны ханш 677 төгрөгт үндэслэн тооцов.

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


2026 оны II улирал

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

18.4% Байвал зохих доод хэмжээ 12.5%


Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

33.3% Байвал зохих доод хэмжээ 25.0%



Түргэн борлогдох актив

2,195.7 тэрбум төгрөг



Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал	2025 IV улирал	2026 I улирал	2026 II улирал
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-2.0%	-4.9%	-0.6%	-1.2%	-3.5%	6.6%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-3.3%	-5.7%	-1.4%	-1.2%	-4.9%	6.9%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	51.7%	46.3%	51.8%	54.8%	53.2%	75.1%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.2%	1.1%	1.1%	1.1%	1.1%	1.0%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.0%	6.8%	6.9%	8.0%	7.6%	8.1%

	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал	2025 IV улирал	2026 I улирал	2026 II улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	1.7%	0.9%	1.0%	2.0%	0.9%	0.7%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%

Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	1.8%	0.9%	1.0%	2.0%	1.0%	0.7%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.3%	0.4%	0.4%	0.3%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	0.0%	0.1%	0.1%	0.1%	0.0%	0.1%

Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хорооны хурал

2026 оны II улирал



ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр танхим болон эчнээ санал хураалтын хэлбэрээр амжилттай зохион байгуулагдсан. Хуралд нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшигчдийн 96.3 хувь оролцсоноор ирц бүрдэж, дараах 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв:

1. ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
3. ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай
4. Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай
5. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай



“Хүүхэд бүр уран бүтээлч” уралдааны 5-7 насны ангиллын тэргүүн байр **Т.Чэчэйхэний** бүтээл.

☎ (976)-75771888-(888)

✉ investor-relations@xacbank.mn

🌐 www.xacbank.mn